



**2024
БҮС НУТГИЙН
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ**

Ирээдүйгээ бүтээх нь:
Ази, Номхон далайн
бүс нутгийн
хүний хөгжлийн
шинэ чиглэл

ХУРААНГУЙ ТОЙМ

ХУРААНГУЙ ТОЙМ



Хураангуй тойм

Хүний хөгжил гэдэг нь хүмүүсийн тухай, тэдний боломж, сонголтыг өргөжүүлж, сайн сайхан байдлыг нь дээшлүүлэх тухай ойлголт юм.

Хүмүүс болоод олон нийт нь хөгжлийн идэвхгүй ашиг хүртэгч бус, харин эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдрал, хүн төрөлхтний аюулгүй байдлын бүтээн байгуулалтад бүрэн оролцож чадах идэвхтэй төлөөлөгч байхын сацуу ирээдүй хойч үеийнхнийхээ төлөө эрүүл орчин, эх дэлхийгээ сахин хамгаалах үүрэг хүлээдэг байх учиртай.

Ази, Номхон далайн бүс нутгийн хүний хөгжлийн замнал нь ахиц дэвшил, тэгш бус байдал, үймээн самуун аль алиныг нь гатлан туулж байна.

Олон сая хүн ядуу тарчиг, хүнд нөхцөлд амьдарч, аюулгүй байдал нь олон төрлийн аюулд өртөх эрсдэлтэй энэ бүс нутаг нь Тогтвортой хөгжлийн зорилгуудын ядаж нэгийг нь тууштай хэрэгжүүлэх замд ороогүй байгаа нь анхаарлын дохиог өгч байна. Нөхцөл байдал олон талаараа улам л төвөгтэй болж байна. Тус бүс нутагт эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд саад учруулж болзошгүй уур амьсгалын өөрчлөлт, хувьсан шинэчлэгдэж буй технологи, бизнесийн орчин зэрэг олон шинэ сорилтууд нүүр тулж байна. Ардчилал, үндэсний институцууд сулран доройтож, олон нийтийн санаа бодлыг туйлшруулж байгаагаас шалтгаалж аливаа үр дүнтэй бодлого хэрэгжүүлэхэд эрсдэл учрах нь нэмэгдсээр байна.

Хүн төрөлхтний хөгжлийн ээдрээтэй нөхцөл байдалд хүний хөгжлийг сэргээх шинэ чиглэлүүдийг тодорхойлж энэхүү Ази, Номхон далайн бүс нутгийн 2024 оны Хүний хөгжлийн илтгэлд тусгалаа. Бүс нутгийн өнгөрсөн үеийн ололт амжилтад тулгуурлан “Ирээдүйгээ бүтээх” илүү бодитой арга замуудыг тодорхойлж, хүний хөгжлийг үндсэн зорилго болгох, эдийн засгийн стратегийг шинэчлэн тодорхойлох, бодитой өөрчлөлт гаргахыг зорих гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй шинэ хандлагыг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний хөгжлийн замнал нь ахиц дэвшил, тэгш бус байдал, үймээн самуун аль алиныг нь гатлан туулж байна.

Тус бүс нутаг нь эдийн засгийн олон өөрчлөлт шинэчлэлийг манлайлж ирсэн түүхтэй.

Тухайлбал, Японы экспортод тулгуурласан аж үйлдвэржилтийн эртний туршлагаас эхлээд Азийн бар улс орнууд бий болсон, Зүүн өмнөд Ази, Өмнөд Ази, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт гээд олон амжилтыг нэрлэж болно. Цаг үеэ олсон үйлдвэрлэлийн хөгжил, нэмүү өртгийн нэгдсэн сүлжээ бий болсон зэрэг эдгээр олон өөрчлөлтүүд нь Ази тивийг дэлхийн үйлдвэрлэлийн төв болгож, олон улс оронд ашиг орлогоо шат ахиулах боломж өгсөн. Одоогийн байдлаар Ази, Номхон далайн бүс нутаг нь дэлхийн нийт үйлдвэрлэлийн гуравны нэгээс илүү хувийг бүтээж байгаа төдийгүй дэлхийн эдийн засгийн өсөлтийн гуравны хоёр орчим хувийг хангах төлөвтэй байгаа нь олон туйлт дэлхийн эдийн засаг руу шилжиж байгааг илэрхийлж байна.

Ази, Номхон далайн бүс нутаг нь хүний хөгжлийн шинэ үзэл баримтлалыг нэвтрүүлсэн анхдагч бүс нутаг юм.

Тухайлбал, Сингапур Улсын нийтийн орон сууцны хөтөлбөр, Бангладеш Улсын бичил санхүүгийн шинэлэг схем, Индонез, Филиппин улсуудын хөдөлгөөнт банк, Бутан, Шри Ланка, Вьетнам улсуудын хүний хөгжлийг дэмжсэн хөтөлбөрүүд зэрэг олон санаачлагыг хэрэгжүүлж ирсэн. Улс орнууд харилцан биенээсээ суралцаж, олон шинэ санааг өөрсдийн онцлог нөхцөлд тохируулан хэрэгжүүлж байна. Энэ нь улс орнуудын эдийн засгийн өсөлт эрчимтэй нэмэгдэж тус бүс нутгийн 1.5 тэрбум гаруй хүн нэн ядуурлаас ангижрахад тус болсон юм.

Эдгээр арга хандлагад суурилан тус бүс нутаг нь урт хугацааны туршид хүний хөгжлийн чиглэлд ихээхэн ахиц дэвшил гаргасан. Сүүлийн гучин жилийн хугацаанд тус бүс нутгийн Хүний хөгжлийн индекс (ХХИ) 19 пунктээр өссөн нь дэлхийд

хамгийн том үсрэлт болсон. Орлогын түвшин огцом өссөний зэрэгцээ насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин 66-гаас 86 хувь, дээд боловсрол эзэмшигчдийн хувийн жин 19-өөс 36 хувь болж тус тус өссөний зэрэгцээ, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нэг мянган амьд төрөлтөд 83-аас 22 болж буурч, төрөлтөөс тооцсон дундаж наслалт 64-өөс 72 жил болж нэмэгдсэн нь гайхалтай амжилт юм.

Гэвч үр ашгийн хуваарилалт тэгш бус байна. Ази-Номхон далайн дэд бүс нутгууд, улс орон хоорондын болоод улс орны дотоод дахь тэгш бус байдал гүн гүнзгий оршсоор байгаа төдийгүй шийдвэр гаргахад оролцох үйл явц нь бүтэц, ашиг сонирхлын явцуу хүрээнд хязгаарлагдсан хэвээр байна.

- **Тэгш бус байдал гүн гүнзгий оршсон хэвээр байна** – Хамгийн чинээлэг 10 хувь нь нийт орлогын талаас илүү хувийг захиран зарцуулж байгаа бөгөөд ялангуяа Өмнөд Азид орлогын тэгш бус байдал улам бүр гүнзгийрч байна. Ялангуяа Зүүн өмнөд Ази, Өмнөд Азийн улс орнуудад баялгийн тэгш бус хуваарилалт ужгирч байгаа бөгөөд БНХАУ, Энэтхэг, Мьянмар, Шри Ланка, Тайланд улсад баялгийн тэгш бус хуваарилалт хамгийн өндөр түвшинд байна. Хүний хөгжлийн ахиц дэвшил бүс нутгийн хэмжээнд мэдэгдэхүйц ялгаатай байна.
- **Олон сая хүн ядууралд нэрвэгдсэн хэвээр байна** – БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт нь хүн амынхаа орлогын ядуурлыг бууруулахад асар их ахиц дэвшил үзүүлсэн хэдий ч үнэмлэхүй утгаараа бүс нутагтаа 185 сая орчим хүн ядуу хэвээр, өдөрт 2.15 доллар хүрэхгүй орлогоор амь зогоож байна. Үүнээс ч олон хүн харьцангуй ядуу амьдарч байгаа бөгөөд тэрбум орчим хүн 'нийгмийн ядуу' гэсэн ангилалд багтаж, орлогын голч үзүүлэлтийн талаас бага орлогоор амьдарч байна. Өөр нэг чухал үзүүлэлт бол боловсрол, эрүүл мэнд, амьжиргааны түвшний гачигдлын хүчин зүйлүүдийг харгалзан тооцох олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ/МРІ) юм. Олон хэмжээст ядууралд өртсөн дэлхийн нийт хүн амын тал хувь нь буюу 500 сая хүн Ази, Номхон далайн бүс нутагт амьдарч байна. Тэдгээрийн 400 сая нь Өмнөд Азийн улс орнуудад амьдарч

байна. Гэтэл Энэтхэг Улс 2005 оноос хойш 415 сая хүнээ олон хэмжээст ядуурлаас гаргаж чадсан түүхтэй.

- **Ази, Номхон далайн бүс нутагт жендэрийн талаарх хэт өрөөсгөл үзэл хандлага оршсоор байна** – Эмэгтэйчүүд боловсрол, эрүүл мэнд, санхүүгийн салбарт амжилт гаргаж байна. Сүүлийн 10 жилийн дотор Өмнөд Азийн улс орнуудын санхүүгийн байгууллагад данс эзэмшдэг эмэгтэйчүүдийн хувийн жин 24-өөс 66 хувь болж өссөн. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд олон янзын өрөөсгөл үзэл, хандлага, бүтцийн саад бэрхшээлд баригдсан хэвээр, зарим улс оронд жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд ихээхэн саад бэрхшээл тулгарсан хэвээр байна. Ялангуяа, Афганистан Улсад хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдэд тулгарч байгаа хязгаарлалтууд онцгой анхаарал татаж байна. Бүс нутгийн хэмжээнд 800 сая орчим эмэгтэй ажиллах хүчний эгнээнээс гадуур байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин Исламын Бүгд Найрамдах Иран Улсад 14 хувь, сургуульд хамрагдалт харьцангуй өндөр хэдий ч Пакистан Улсад 25 хувь, Вьетнам Улсад 69 хувь байна.
- **Олон сая хүн албан бус салбарт ажиллаж байгаагийн зэрэгцээ дижитал хуваагдал илт ажиглагдаж байна** – Албан бус салбарт ажиллаж буй дэлхийн нийт хүн амын гуравны хоёр орчим хувь буюу 1.3 тэрбум орчим хүн Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад ажиллаж байна. Өмнөд Азийн улс орнуудын нийт ажиллагсадын 87 хувь нь албан бус салбарынхан байгаа бол Зүүн Азийн улс орнуудын нийт ажиллагсадын 50 хувь нь албан бус салбарын ажиллагсад байна. Улс орнуудын түвшинд авч үзвэл, Тонга Улсын нийт ажиллагсадын 97 хувь нь албан бус салбарт ажиллаж байгаа буюу хамгийн өндөр байхад БНСУ-ын нийт ажиллагсадын 27 хувь нь албан бус салбарт ажиллаж байгаа буюу хамгийн бага байна. Түүнчлэн, цахим технологийн хүртээмжийн хувьд ихээхэн ялгаатай байна. Тус бүс нутгийн нийт хүн амын 40 хувь нь цахим технологи хэрэглэх боломжоор хангагдаагүй, хүйсээр болон хот, хөдөөгийн түвшинд мэдэгдэхүйц ялгаатай байна.

- **“Эх дэлхийд дарамт учруулах” байдлаараа мэдэгдэхүйц ялгаатай байна** – Ази, Номхон далайн бүс нутагт хүлэмжийн хийг их, бага хэмжээгээр ялгаруулагч улс орнууд, түүнчлэн Бутан зэрэг ногоон улс орнууд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд хамгийн ихээр өртөж буй цөөнгүй улс орон байдаг. Ази Номхон далайн бүс нутгийн хувьд эрчим хүчний хэрэглээнийхээ 85 хувийг түүхий нүүрсээр хангаж байгаа бөгөөд сүүлийн 30 жилийн хугацаанд дэлхийн нийт нүүрсхүчлийн хий (CO₂) ялгаралтад оруулж буй хувь нэмэр нь дөрөвний нэгээс тал хувь нь болтлоо нэмэгдсэн байна. Амьдрах орчны хомсдол, бохирдол, хэт ашиглалт, хор хөнөөлтэй амьтдын аюул зэргээс шалтгаалан манай гарагийн биологийн олон янз байдал аюул эрсдэлд орж байгаа төдийгүй уур амьсгалын өөрчлөлт үүнд улам бүр нэрмээс болж байна. 1970 оноос хойш Ази-Номхон далайн бүс нутаг нь биологийн олон янз байдлын доройтлоороо Латин Америк, Африкийн бүсийн дараа буюу дэлхийд гуравт орох болсон. Экологийн болоод байгаль орчны эдгээр дарамт нь ой модоо түшиглэн амьдардаг тус бүс нутгийн 200 гаруй сая хүний эрүүл мэнд, амьжиргаанд эрсдэл учруулж байна. Байгаль орчны эдгээр дарамтыг харгалзан үзвэл хүний хөгжлийн хэтийн төлөв байдал бүдгэрч, ялангуяа экологийн ул мөр ихтэй баян чинээлэг орнуудын хувьд улам бүр бүрхэг болж байна.

Дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд КОВИД-19 цар тахал, Украины дайны нөлөө, амьжиргааны өртгийн хямрал зэрэг амаргүй олон сорилтыг даван туулж байна.

- **Цар тахал болон түүнээс шалтгаалсан хөл хорио хязгаарлалтууд нь тус бүс нутгийн албан бус ажиллах хүчний тал орчим хувьд хүндээр нөлөөлсөн** – Цөөнгүй тооны улс орны аялал жуулчлалаас олох орлого, мөнгөн гуйвуулга тасалдаж, олон тооны ажилчдыг албан бусаар ажиллуулдаг үйлдвэрүүд зогсож, ялангуяа Номхон далайн арлын орнууд ноцтой хохирол амссан. Гэнэтийн энэхүү цочрол Өмнөд Ази болон Зүүн өмнөд Азийн улс орнуудын эрүүл мэндийн хүч султай тогтолцоонд хүндхэн

цохилт болсон. Үргэлжлээд Украины дайн, түүнийг дагасан амьжиргааны өртгийн хямрал нүүрлэж эхэлсэн. 2020, 2021 онуудад цар тахал болон эдгээр хямралууд хавсран Зүүн Азийнхаас бусад бүх дэд бүс нутгийн Хүний хөгжлийн индекс ихээхэн хэмжээгээр буурахад хүргэсэн. Макро эдийн засгийн болоод өрийн хямралд орсон улс орнууд ихээхэн хохирол амссан.

- **Ядуу өрхийн эмэгтэйчүүдэд хамгийн хүнд туссан** – Бүс нутагт сүүлийн 20 жилийн хугацаанд, ялангуяа Өмнөд Ази, Номхон далайн бүс нутагт жендэрийн эрх тэгш байдал хамгийн ихээр алдагдсан. Цар тахлын үед эмэгтэйчүүд нь гэр орны ажил хийх, хүүхэд асрах, гэр бүлийнхээ өвчтэй, өндөр настай гишүүдийг асран халамжлах зэрэг гэр бүлийн үүрэг хариуцлагын ачааллын хүндийг үүрч байв. 2020, 2021 онуудад Папуа Шинэ Гвиней, Мьянмар улсууд, ялангуяа Афганистан улсад эмэгтэйчүүдийн үндсэн эрх, эрх чөлөөг ноцтойгоор зөрчиж, олон арван жилийн ахиц дэвшлийг урвуугаар нь эргүүлсэн.
- **Уур амьсгалын өөрчлөлтийн тухайд сайн санаачлагууд ажил хэрэг болох нь хязгаарлагдмал байгаа бөгөөд нүүрсхүчлийн хий (CO₂) ялгаралт нэмэгдсээр байна** – 2022 оны 8-р сард нүүрсхүчлийн хийн ялгаралтыг сааруулах амлалтыг 30 улс орон өгсөн боловч тэдгээрийн дийлэнх нь энэхүү амлалтаа хэрхэн биелүүлэх талаар сайн бодож боловсруулсан санхүүжүүлтийн стратеги байхгүй байна. Тухайлбал, 2022 онд гэхэд л Индонези Улс нүүрсний хэрэглээгээ өмнөх оныхоосоо 33 хувиар нэмэгдүүлсэн байна. Улс орнууд эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулахад ихээхэн ач холбогдол өгч байгаа бөгөөд өсөн нэмэгдэж буй гадаад өрөө бууруулахын тулд нүүрсний экспортыг ашиглаж байна.
- **Эцэст нь, сүүлийн 10 жилийн хугацаанд тус бүс нутгийн ардчиллын практикт зарим өөрчлөлт гарсан** – Цар тахал нь улс орнуудад иргэний эрх чөлөөг хязгаарлах, улс төрийн эрхийг зөрчих, хариуцлагын механизмыг сулруулах боломж бүрдүүлсэн. Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад тэртээ 1970-аад оны сүүлчээр ажиглагдаж байсан хэмжээнд олон нийтийн болоод иргэний орон зайг хязгаарлах

хандлага сүүлийн үед ажиглагдах болсон бөгөөд ардчилал нэн даруй сэргэх найдвар бараг ажиглагдахгүй байна. Энэ нь зарим улс орнуудад хөгжлийн ерөнхий замнал, хүртээмж, тэгш байдалд ноцтой нөлөө үзүүлж байна. Дээр өгүүлсэн хандлага нь монополь байдлыг бий болгох аваас эдийн засгийн өрсөлдөх чадварыг бууруулна.

Тавьсан зорилго биелэгдэхгүй, хүний аюулгүй байдал алдагдаж эхэлсэн, улам бүр хямрах эрсдэлтэй болж байгаа ирээдүй зэрэг нь яаралтай өөрчлөлт хийх хэрэгцээг бий болгож байна.

Өнөөгийн чиг хандлагаас харахад, тус бүс нутаг нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын ядаж нэгийг нь ч тууштай хэрэгжүүлэх замд ороогүй байна. Хүсэл зорилго болон бодит байдал нь мэдэгдэхүйц зөрүүтэй байгаагаас уур амьсгалын өөрчлөлтийн талаарх зорилтуудыг хэрэгжүүлэхэд ноцтой ухралт гарч байна. ТХЗ-ууд нь 2030 он гэхэд хэрэгжихээргүй, харин 2065 он гэхэд л биелэгдэж магадгүй байна. Гэсэн хэдий ч 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн мөн чанар, санаа зорилго урьдын адил хүчинтэй хэвээр байгаа билээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн олон сая хүмүүс нийгэм, улс төр, байгаль орчны аюулгүй байдал нь эрсдэлд орсон хүнд, аюултай нөхцөлд амьдарч байна. Ялангуяа Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн улс орнууд зөрчил мөргөлдөөн, улс төрийн үймээн самуун, эдийн засгийн хүндхэн саад бэрхшээлийг даван туулах гэж тэмцэж байна. Тавьсан зорилго биелэгдэхгүй, хүний аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй нөхцөл үүссэн зэрэг нь тогтворгүй байдлыг бий болгож, хүний цогц хөгжлийг хангахад хүндрэл учруулах нь гарцаагүй.

Харилцан үйлчлэл бүхий дараах гурван бүлэг эрсдэл хөгжлийн төлөв байдалд нөлөөлөх учир тус бүс нутаг ч мөн адил илүү хүнд ирээдүйтэй нүүр тулж болзошгүй байна.

- *Оршихуйн эрсдэлүүд – Оршин тогтноход учрах хамгийн ноцтой аюулын нэг бол уур амьсгалын өөрчлөлт юм.* Түүнчлэн, ирээдүйд КОВИД-19 цар тахалтай төстэй тахал гарч болзошгүй

бөгөөд ийм аюул ойрын 25 жилийн дотор дахин давтагдах магадлал ойролцоогоор 50 хувьтай байна. Эдгээр эрсдэл нь хүн төрөлхтөн байгальтай харьцах үйл явц арга замаас шалтгаалан нэмэгдэнэ. Хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, эдийн засгийн сонирхол зэргээс шалтгаалан хотууд хурдацтай хөгжиж байгаа бөгөөд тус бүс нутагт Токио, Мумбай зэрэг дэлхийн хамгийн том хотууд, далайн эргийн зургаан мега хот оршиж байна.

- *Эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэх механизмд тулгарах сорилтууд –* Баян чинээлэг улс орнуудын хүн амын насжилт нь эрүүл мэнд, нийгмийн тогтолцоонд нь дарамт учруулах сорилт тулгарч байгаа бол буурай хөгжилтэй улс орнууд залуусаа ажилтай болгож, зайлшгүй шаардлагатай суурь үйлчилгээгээр хангахыг зорьж байна. Өмнөд Азийн улс орнуудын залуу ажилчдын 80 хувь нь албан бус салбарт ажиллаж, 30 хувь нь сургуульд сурахгүй, ажил хөдөлмөр эрхлэхгүй байна. Залуучуудын ажилгүйдлийн түвшин буурахгүй байгаа төдийгүй хэд хэдэн оронд нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ геополитикийн хурцадмал байдал, чинээлэг орнуудын эдийн засаг удаашралтай сэргэж, тэгш бус байдал өсөн нэмэгдэж байгаа зэрэг нь даяаршлыг сулруулж байна. Технологийн хурдацтай өөрчлөлт, эрчим хүчний шилжилт нь шинэ боломжуудыг бий болгож байгаа ч хөдөлмөрийн зах зээл, өрсөлдөх чадварт томоохон сорилтуудыг үүсгэж байна.
- *Өөрчлөлтийн эрч хүчинд нөлөөлөх эрсдэлүүд –* Хүсэл зорилго хангагдахгүй, тодорхойгүй байдал үүсэж буй эрин үед ардчиллын ухралт, популизм нэмэгдэж, туйлшрал, нийгмийн мэдээллийн платформ дахь өсөн нэмэгдэж буй буруу ташаа мэдээлэл зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр шинэчлэл хийх боломж хумигдсаар байна. Үүний зэрэгцээ дижитал технологи нь олон ашиг тусыг авчрах хэдий ч сөрөг үр дагаврыг дагуулж болзошгүй байна. Нээлттэй хандалтыг хадгалах нь чухал боловч, тухайлбал, хиймэл оюун ухаанд суурилсан нийгмийн мэдээллийн платформууд нь олон нийтийн санаа бодлыг төрүүлэх, талцал хуваагдлыг өдөөх зэрэгт асар их үүрэг гүйцэтгэх болсон. Туйлширсан үзэл бодол өрнөсөн орчинд алсын

хараатай өөрчлөлтийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх нь улам амаргүй болж байна.

Эдгээр бүлэг эрсдэл болон тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд нь харилцан өөр хоорондоо давхцана.

Жишээлбэл, хотжилт нь нэг талаас халдварт вирусн тархалт дэгдэх таатай нөхцөлийг бүрдүүлж болох хэдий ч нөгөө талаас хүмүүс, бизнесийн харилцааг ойртуулж эдийн засгийн өсөлтийг дэмжих боломж бий болгодог. Хиймэл оюун ухаан, нийгмийн мэдээллийн хэрэгслийн ашиглалт нь эерэг дадал, зохицуулалтын үйлдлээр дэмжигдээгүй тохиолдолд зөвхөн ажлын байрыг алдагдуулаад зогсохгүй талцал зөрчилдөөнийг улам хурцатгаж, буруу ташаа мэдээлэл түгээх замаар бодлогын хэрэгжилтэд саад учруулж болзошгүй юм. Бодлогын арга хэмжээ авах замаар эдгээр бүлэг эрсдлийг сааруулахад нөлөөлөх боломжтой. Тухайлбал, оршихуйн эрсдэлийг бууруулахын тулд нарны эрчим хүчийг ашигласнаар эдийн засгийн өсөлтийг дэмжих шинэ хөдөлгүүрийг идэвхжүүлэх боломжтой.

Хүний хөгжлийн шинэ чиглэлийг тодорхойлохын тулд өмнөх дадал зуршлаа шинэчлэх шаардлагатай хэдий ч бүс нутгууд өөрийн туршиж батлагдсан загварт түшиглэх нь зүйн хэрэг юм.

Тус бүс нутгаас эхтэй экспортод суурилсан өсөлт, хүний хөгжлийн загвар нь үзэл баримтлал, түшиг тулгуурын баялаг эх сурвалж хэвээр байгаа ч илүү үр дүн гаргахын тулд өөрчлөлт хийхэд дасан зохицох шаардлагатай. Ази-Номхон далайн бүс нутаг нь экспортод суурилсан өсөлтийн стратегийн өлгий нутаг бөгөөд Өмнөд Азийн нэрт хоёр эдийн засагчийн их бүтээл болох хүний хөгжлийн үзэл баримтлалыг олон улс орон хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч 21-р зуунд илүү чинээлэг, тэгш, байгаль орчинд ээлтэй, тогтвортой үр дүнд хүрэхийн тулд эдгээр загварыг өөрчлөн шинэчилж, орчин үед нийцүүлж, түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна. Ялангуяа, өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхээ эрх ашгийг ухамсарлаж, хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэхийн тулд хүний хөгжлийн загварыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн экспортод суурилсан эдийн засгийн өсөлтийн загвар нь цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж, зөв өсөлтийг бий болгож, хангалттай ажлын байр бий болгож, хүний хөгжлийг илэрхийлэх бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэж шинэчлэгдэх шаардлагатай.

Гэвч жинхэнэ утгаараа 'ирээдүйгээ бүтээнэ' гэдэг нь нэг алхам урагшилж, шинэчлэлийн засаглал, бодлогыг шийдвэрлэнэ гэсэн үг юм.

Үзэл бодлыг ажил хэрэг болгон хувиргахад илүү идэвхтэй, алсын хараатай манлайлал шаардлагатай. Алсыг харсан, дасан зохицох чадвартай, шуурхай шийдвэр гаргах чадамжтай авхаалж самбаатай засаглал байх аваас шинэчлэгдсэн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл, хөрөнгө нөөцийг шуурхай шийдвэрлэх боломж бүрдэнэ. Ийм засаглалын тогтолцоо нь зөвшилцөл, хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгохын зэрэгцээ алсын хараатай хөгжлийг дэмжиж, тэргүүлэх салбарууд, хүний нөөцийг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих боломжтой. Өөрчлөлтийг илүү суурь түвшинд өөрсдөө өдөөх нь чухал юм. Ингэхийн тулд нийгэм-улс төрийн саад бэрхшээл, тэдгээрийг тойрон гарах арга замыг сүвэгчлэн олох талаар илүү нухацтай судалж, илүү их анхаарал хандуулах шаардлагатай.

Өнөө болон хойч үеийнхний хэрэгцээ шаардлагыг эн тэргүүнд тавьснаар улс орнууд хүн бүрийн боломжийг өргөжүүлж, хүний аюулгүй байдлыг хангаж, хойч үеийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадна.

Хүний хөгжлийн үйл хэргийг бүс нутгийн шийдвэр гаргах үндсэн чиглэлүүдтэй илүү нягт уялдуулах боломж байна. Сүүлийн үеийн үймээн самуун, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал нь хүн төвтэй хөгжил, хойч үеийнхний дуу хоолойг орхигдуулахад хүргэж байна. Хөгжлийн хандлагаа шинэчлэхэд чиглэсэн бидний төсөөлж буй өөрчлөлтөөр энэхүү тэнцвэргүй байдлыг арилгах нь юу юунаас чухал болж байна. Үүний тулд дараах тэргүүлэх гурван чиглэлийг онцолж байна. Тухайлбал,

Нэгдүгээрт - Хүмүүсийн сонголтыг өргөжүүлэх.

- **Амь бөхтэй орших бүтцийн гадуурхалыг арилгаж, хүний нэр хүндийг дээдлэх.** Үүнд эмэгтэйчүүд, залуучууд, албан бус хөдөлмөр эрхлэгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ЛГБТКИ+ (лесби, гей, бисексуал, трансжендэр, интерсекс, күйр) хүмүүс болон орхигдох эрсдэлтэй хүмүүс хамаарна. Эцсийн зорилго эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан аливаа хууль, хэм хэмжээ, үйлдлийг таслан зогсоох, хөгжлийн бэрхшээлтэй болон ЛГБТКИ+ хүмүүсийн эрх ашгийг хамгаалахад чиглэх ёстой. Үндсэндээ өргөн хүрээг хамарсан албан бус ажиллах хүчийг илүү сайн ажлын байраар хангах, залуучуудыг үр бүтээлтэй ажил хөдөлмөр эрхлэхэд нь тус болох боловсролыг эзэмшүүлэх зэрэг нь үүнд багтана. Энэ нь хүний үндсэн эрхийг хангах баталгаа юм. Энэ нь бизнест ч тустай. Зөвхөн эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангаснаар 2025 он гэхэд тус бүс нутгийн ДНБ-ийг 4.5 их наяд ам.доллараар өсгөх боломжтой бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр ДНБ-ийг нэгээс долоон хувиар нэмэгдүүлэх боломж байна.
- **Чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хүний чадамжийг тэлэх.** Сургалтын арга барилыг шинэчилж, дижитал боловсролыг түлхүү олгож, сургалтын хөтөлбөрийг зах зээлийн хэрэгцээ шаардлагад сайтар нийцүүлэх шаардлагатай. Жишээлбэл, Бангладешийн a2i Багшийн портал нь хагас сая гаруй багш нарт дижитал ур чадвар олгосон байдаг. Энэ нь мөн бүх нийтийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулахад туслах арга ч болж болох юм. Дээрх бүх зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүн бүрийн чадамжийг тэлэх боловсрол, эрүүл мэндийн тогтолцоо, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх улс орны шийдвэр гаргах дээд түвшний амлалт, хүсэл зориг шаардагдана.

Хоёрдугаарт – Хүний аюулгүй байдлыг сайжруулах.

Улс орнууд гэнэтийн цочролын нөлөөллийг сааруулахын зэрэгцээ хүний аюулгүй байдалд заналхийлж буй үндсэн шалтгааныг дараах байдлаар шийдвэрлэх боломж байна.

- **Нийгмийн хамгааллын өөрчлөлт шинэчлэл.** Нийгмийн хамгааллын үндэсний нэгдсэн тогтолцооны хүрээнд ялангуяа албан бус салбарт ажиллагсад, ядуурлын шугамаас дээхнүүр орлоготой эмзэг бүлгийнхэн буюу “орхигдох эрсдэлтэй дунд” бүлгийнхэнд ур чадвар олгох, хөдөлмөр эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэхийн зэрэгцээ мөнгөн дэмжлэг үзүүлэх боломжтой. Жишээлбэл, Сингапур Улс нь бүх насны хүмүүсийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд насан туршийн боловсролыг чухалчилж байна. Түүнчлэн хүн амын амьжиргааг дэмжих, санхүүгийн хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн тэтгэмж зэрэг хөтөлбөрүүдтэй мөнгөн дэмжлэгийн хөтөлбөрийг хослуулж эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн эрсдлийг даах чадварыг сайжруулахад тусалж болохыг Непал Улсын жишээ харуулж байна.
- **Эрүүл мэндийн тогтвортой тогтолцоог бэхжүүлэх.** Үүнд бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулахад (УНС) зориулсан төв, орон нутгийн эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалт хамаарна. Ялангуяа хүн ам нь насжиж буй улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоонд илүү тогтвортой санхүүжилт хэрэгтэй. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ авах боломж олгохын зэрэгцээ эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй шийдлийг олоход тусална. Жишээлбэл, Тайланд Улс нь бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах эхлэлийг баттай тавьсан бол Филиппин Улс архи, тамхины татварын шинэчлэл хийх замаар бүх нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүн амынхаа хамгийн эмзэг хэсгийг хамруулж үр дүнтэй өргөжүүлж байна.
- **Эрсдлийг тооцоолсон хөгжилд хөрөнгө оруулах.** Ази, Номхон далайн бүс нутаг нь байгалийн гамшигт ихээхэн өртөж байгаа тул орчин үеийн технологийн шинэчлэлийг бүрэн ашиглаж, ялангуяа далайн эрэг орчмын бүс нутгийн хүн амын бүлгүүдийн эрсдлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн улс орнуудад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс дайжсан шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтийн асуудал тулгарч байгаа

бөгөөд үүнд бүс нутгийн хамтын ажиллагаа чухал. Байгалийн гамшигт өртөмтгий улс орнуудын дийлэнх нь хангалттай санхүүжилт босгохыг зорьж ирсэн. Жишээлбэл, Тонга Улсын Засгийн газар нь болзошгүй эрсдэлд бэлэн байдлыг хангах зорилгоор Тогтвортой хөгжил, санхүүгийн хэлтсийг байгуулан Сангийн яамныхаа төлөвлөлт, төсвийн бүтцэд оруулсан байна.

- **Хүнсний аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх.** Улс орнууд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах, найдвартай нийлүүлэлтийн сүлжээ байгуулах чиглэлд хөрөнгө оруулалт хийхээс гадна газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих боломжтой. Жишээлбэл, Сингапур Улс нь 2030 он гэхэд хүнснийхээ хэрэглээний 30 хувийг Вертикал аж ахуйгаар (vertical farming) хангахаар зорьж хөдөө аж ахуйн технологийн шинэлэг аргыг судалж байна. Үүний нэгэн адил Тайланд, Пакистанд улсууд нь финтек, хөдөө аж ахуйн технологи зэрэг хиймэл оюун ухаан, дэвшилтэт судалгаа шинжилгээг ашиглаж үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, жижиг хэмжээний тариалан эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Гуравдугаарт – Хойч үеийнхнийхээ эрх ашгийг хамгаалах.

Тус бүс нутаг нь нүүрсхүчлийн хийн ялгаруулалт багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжил рүү нэн даруй шилжих шаардлагатай байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтөд өртөж зовж шаналж буй хүмүүсийг хамгаалахын зэрэгцээ хойч үеийнхнийхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлнэ.

- **Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийг хурдасгаж, хүлэмжийн хийн ялгаруулалт, шингээлтийн зөрүүг арилгах.** Өсөн нэмэгдэж буй ногоон эрчим хүч буюу нар, салхи, усны эрчим хүчийг системчилсэн аргаар зохицуулан эрчим хүч түгээх сүлжээг сэргээж, бэхжүүлэх боломж байна. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх өргөн хүрээний сүлжээтэй бүс нутагт сэргээгдэх эрчим хүч рүү шилжихэд амаргүй байж болно. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээг бүрэн шинэчилж

зүгширтэл сүлжээний бус шийдэл нь түр зуурын авах арга хэмжээ байж болно. Үүний зэрэгцээ, түүхий түлш хэрэглэдэг салбарын ажилчдыг дахин сургах замаар тэдэнд ногоон ажлын байранд шилжих боломж олгох ёстой. Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийг бий болгоход нийгмийн хамгаалал нэн чухал бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх цочролыг даван туулах, улмаар амьдралынхаа туршид аливаа боломжийг самбаачлан ашиглах чадварт эмзэг бүлгийн хүмүүсийг сургах хэрэгтэй.

- **Дасан зохицох болон гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд хөрөнгө оруулах.** Ази, Номхон далайн бүс нутгийн 27 улс орон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөгөө шинэчилсэн хэдий ч бүс нутгийн уур амьсгалын санхүүжилтийн дөнгөж 8 хувь нь дасан зохицох чиглэлд зориулагдаж байна. Тухайлбал, Шри Ланка Улс 2016 онд Үндэсний дасан зохицох төлөвлөгөөгөө боловсруулан баталж манлайлж байсан бол Бангладеш, Пакистан, Папуа Шинэ Гвиней улсууд удаалж байжээ. Гэсэн хэдий ч санхүүжилт хангалтгүй ихээхэн дутагдалтай байгааг шийдвэрлэхийн тулд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай. Санхүүжилтийн дутагдаж буй хэрэгцээг хангах механизмуудын нэг бол НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн цаг уурын байгууллага, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн хамтран 2021 онд байгуулсан Системчилсэн ажиглалтын санхүүжилтийн сан (CACCS/OFF) юм.
- **Экосистемийг хамгаалах, биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд байгаль орчинд хор хөнөөл учруулах эрсдэлтэй үйл ажиллагаанд татаас өгөхийг хориглох.** Жишээлбэл, Папуа Шинэ Гвиней Улс экосистемийн үйлчилгээний зах зээлийн үнэ цэнийг судалж байгаа бол Шри Ланка Улс далай тэнгисийн загас агнуур, эрчим хүч, хөдөө аж ахуй, эрэг орчмын загасны аж ахуй, тээвэр зэрэг салбарт татаас олгох нь эдийн засгийн ямар үр нөлөөтэй байгааг судалж байна.
- **Төсвийн санхүүжилтийг илүү хариуцлагатай удирдах.** Ирээдүй хойч үеэ өрийн дарамтад оруулснаар хүний хөгжлийг сааруулна. Өрийн идэвхтэй удирдлага, орлого төвлөрүүлэлт,

ТХЗ-д чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих нь маш чухал. Камбож, Балба зэрэг Ази-Номхон далайн бүс нутгийн зарим улс орнууд эдгээр туршлагаас ашиг тус хүртсэн байдаг. Энэтхэг, БНСУ, Малайз, Тайланд зэрэг улс орнууд үндэсний валютынхаа өрийн эрсдэлийг бууруулсан. Гамшгийн үеийн өр түдгэлзүүлэх заалт буюу 'өр-байгалийн/ТХЗ своп хэлцэл' зэрэг шинэлэг арга хэрэгслүүд нь ТХЗ-ын хөрөнгө оруулалтын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг нээнэ.

Системийн томоохон асуудлыг шийдвэрлэхийн тулд улс орон бүр шаардлагатай нөхцлүүдийг хэлэлцэж хөрөнгө нөөц дайчлах, хуваарилах стратеги боловсруулах боломжтой.

Эмэгтэйчүүдийн эрх, баялагийн хүртээмжид тэгш, шударга хандах зэрэг хүний хөгжлийн зарим асуудлыг хэлцэл тохиролцоогоор шийддэггүй. Гэхдээ төсвийн санхүүжилтийг нухацтай хэлэлцэх нь гарцаагүй бөгөөд үүнд харилцан тохиролцоо, буулт хийх шаардлага гарна. Ийм асуудлыг шийдвэрлэхдээ улс орнууд санхүүжилтийн цогц арга барилыг хэрэгжүүлэх замаар төсвийн хөрөнгийг оновчтой болгох, хувийн санхүүжилтийг идэвхжүүлэх, эдийн засгийн өсөлтөд таатай орчинг бүрдүүлэх, хамгийн их нөлөө үзүүлэх салбарууд руу шууд хөрөнгө оруулалтыг хийх зэргээр хүний хөгжилд илүү их хөрөнгө нөөцийг чиглүүлэх боломжтой.

Улс орнууд эдийн засгийн стратегиа шинэчлэн боловсруулснаар эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэх шинэ арга замыг нээж, боломж, хөгжил цэцэглэлт, аюулгүй байдлыг хангах эерэг эргэлтийг идэвхжүүлж чадна.

Эдийн засгийн өсөлт нь төсөөллийг өдөөж байдаг. Энэ нь ямар өөрчлөлт авчирч болох талаар бодож үзэх нь чухал. 1700-д оны дэлхийн тэргүүлэх эдийн засагтай орнуудын нэг хүнд ногдох орлого нь Афганистан, Непал улсуудын 2018 оны үзүүлэлтээс давж байгааг Мэддисоны Төслийн олон жилийн харьцуулалтаас ажиглаж болохоор байна. 1870 он гэхэд тухайн үеийн тэргүүлэх эдийн засагтай орнуудын үзүүлэлт өнөөгийн Бангладеш, Камбож улсуудын үзүүлэлтээс ч өндөр байжээ. Түүнчлэн Энэтхэг,

БНАЛАУ, Мьянмар, Пакистан, Вьетнам зэрэг улсуудын 2018 оны орлогын үзүүлэлт нь зуугаад жилийн өмнөх үеийн дэлхийн тэргүүлэх эдийн засагтай орнуудын үзүүлэлтэд ч хүрэхгүй байна. Хэдийгээр эдгээр харьцуулалт нь хэт үнэмлэхүй, харьцуулшгүй мэт санагдаж болох ч эдийн засгийн болоод түүхийн суурь язгуураар нь авч үзвэл эдийн засгийн тогтвортой, тууштай өсөлтөөр илүү их ахиц дэвшилд хүрэх асар том боломж байгааг илэрхийлж байна.

Хүний хөгжилд эдийн засгийн өсөлт зайлшгүй шаардлагатай хэвээр байгаа ч энэ нь зөв өсөлт байх ёстой.

Ази, Номхон далайн бүс нутагт бусад бүс нутгийн нэгэн адил эдийн засгийн өсөлт нь боломж, хөгжил цэцэглэлтийн эерэг эргэлтийг бий болгохын зэрэгцээ аюулгүй байдлыг хангах замаар ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Гэхдээ эдийн засгийн өсөлтийн хурдаас гадна түүний төлөв байдал, чанарыг анхаарч үзэх нь чухал. Тухайлбал, өсөлтийг хэт эрхэмлэх нь хүний эрхийн талаар бага анхаарч, хүмүүсийг хангалтгүй цалингаар, хөдөлмөрийн муу буюу аюултай нөхцөлд олон цагаар ажиллуулахад хүргэнэ. Хэрэв өсөлтийн үр өгөөжийг албан эдийн засаг дахь илүү хүчирхэг бүлгүүд голчлон хүртэж байгаа бол хүн амын дийлэнх хэсэг нь албан бус салбарт үлдэж, гадны нөлөөнд илүү өртөмтгий болох далд эдийн засгийг үүсгэж болзошгүй юм. Цаашлаад, эдийн засгийн хурдацтай өсөлт нь ихэвчлэн байгаль орчинд асар их ул мөрийг үлдээдэг.

Шинэ эрин зууны тогтвортой өсөлтийн стратеги нь экспортод суурилсан өсөлтийн шинэ хандлагыг шаардана.

Олон улс орнууд худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) болон технологитой холбоотой экспортод тулгуурласан өсөлтийг эрэлхийлэх болно. Гэвч гадаад зах зээлийн нөхцөл байдал улам өрсөлдөөнтэй болохын хэрээр өрсөлдөх чадвар, төрөлжүүлэлтэд онцгой анхаарал хандуулах нь илүү чухал болж байна. Үүний зэрэгцээ ажилчид ур чадвараа хөгжүүлэх, суралцахын зэрэгцээ цалин хөлсний шударга бодлого, хөдөлмөр эрхлэх эрхээ эдлэхийг шаардана. Экспортод чиглэсэн үйлдвэрлэл, тэр дундаа чөлөөт худалдааны бүс дэх үйлдвэрүүдийг дотоодын эдийн засагтай

холбож орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээх боломжтой. Бангладеш, Камбож, Филиппин, Вьетнам зэрэг улсууд энэ чиглэлд ахиц дэвшил гаргаж байгаа ч илүү ихийг хийх орон зай нэлээн байна.

Үүний зэрэгцээ улс орон бүр дотоодын зах зээлийнхээ боломжийг дээд зэргээр нэмэгдүүлэх боломж байна.

Энэ нь ялангуяа томоохон улс орнуудын хувьд нэн чухал юм. Төв, орон нутгийн засаг захиргаад зохицуулалтын хэм хэмжээг уялдуулж, тээвэрлэлтийг сайжруулах, орон нутгийнхныг тодорхой бараа, үйлчилгээнд дагнан мэргэшихийг дэмжих зэргээр дотоод худалдааг хөгжүүлэх боломжтой. Ази, Номхон далайн бүс нутгийн олон орны ажиллагсадын дийлэнх хэсэг нь албан бус эдийн засгийн салбарт ажиллаж, байгууллагын дэмжлэг, нийгмийн хамгаалал, сургалтад хамрагдах боломжоор хомс байна. Улс орнууд албан ёсны ажиллах хүчинд нэгдэх боломжийг илүү олон хүнд нээх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилчдын эрхийг хамгаалахад анхаарахын зэрэгцээ албан бус салбарт ажиллагсадын амьжиргааг сайжруулах боломжтой. Мөн жендэрт суурилсан саад бэрхшээлийг арилгах, эмэгтэйчүүдэд тэгш боломж олгох нь амин чухал юм. Бүс нутгийн хүн амын тал хувийн үндсэн эрхийг хамгаалах энэхүү алхам нь эдийн засгийн том давуу талыг бий болгоно. Энэ нь ур чадвартай, бизнес эрхлэх сэтгэлгээтэй, дутуу ашиглагдаж буй авъяас чадварын нөөцийг ашиглах боломжийг улс орнуудад олгоно.

Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд нь дараах дөрвөн салбарын оньсыг нээх таатай боломж байна.

- **Үйлдвэрлэл** – Сүүлийн хорин жилийн хугацаанд олон улс орон аж үйлдвэржилтээ аажмаар сулруулснаар үндэсний эдийн засагт аж үйлдвэрийн салбараас оруулах хувь нэмэр буурахад хүрсэн. Үүнийг эртэдсэн үзэгдэл хэмээн үзэх боломжтой. Үйлдвэрлэл нь хөдөлмөрийн стандартыг сулруулах, байгаль орчинд хор нөлөө учруулах, бүлэглэл үүсэх зэрэг анхаарвал зохих гаж нөлөөг бий болгох тал бий. Гэхдээ үйлдвэрлэлийг худалдаа, инновацтай холбосноор олон ашиг тусыг авчрах боломжтой.
- **Үйлчилгээ, хөдөө аж ахуй** – Технологийн өөрчлөлт нь үйлчилгээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбар хоорондын уламжлалт ялгааг арилгаж байна. Бүтээмжийг дээд зэрэгт нь хүртэл нэмэгдүүлэхийн тулд “agriculture 3.0” систем нь Дэлхийн байршил тогтоох систем (GPS), бусад дижитал болон биохимийн технологийг бүрэн хэмжээнд нь ашиглаж үйлдвэрлэл болон үйлчилгээ үзүүлэгчдээс оруулж буй хувь нэмэрт улам бүр тулгуурлах болсон. Иймээс эдгээр гурван салбарын харилцан огтлолцын цэгт ихээхэн боломж байна.
- **Ногоон, цэнхэр, ягаан эдийн засаг** – Ногоон эдийн засаг буюу нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг хязгаарлах хэрэгцээ шаардлага нь нэмүү өртгийн сүлжээ болон дэд бүтцэд шинэчлэл хийх, тухайлбал, Европын Холбооны Нүүрстөрөгчийн хилийн зохицуулалтын механизмд дасан зохицох боломжийг бүрдүүлнэ. Цэнхэр эдийн засгийн хувьд бүс нутгийн далай тэнгисийн баялаг нөөцийг шинэ технологи, хөрөнгө оруулалтаар оновчтой зохицуулж, тогтвортой ашиглах боломжтой бөгөөд энэ нь хөгжиж буй арлын жижиг улс орнууд болон далай тэнгисийн эрэг дагуух улс орнуудын хувьд онцгой ач холбогдолтой юм. Ягаан (халамжийн) эдийн засагт охид, эмэгтэйчүүд гэр орныхноо асран халамжлахын зэрэгцээ гэрийн ажлыг ихэвчлэн олон цагаар цалин хөлсгүйгээр хийж байна. Иймд хүйсээр ялгаварлалгүйгээр, бизнесийн болоод төрийн үйлчилгээг үзүүлж, эмэгтэйчүүдэд эдийн засаг, улс төрийн үйл хэрэгт идэвхтэй оролцох боломжийг олгох хэрэгтэй.
- **Технологийн өндөр хөгжил** – Төрөл бүрийн салбар дахь технологийн хурдацтай хөгжил нь үйлдвэрлэлийн салбар шинэчлэгдэх, үйлдвэрлэлд нэвтрэх саадыг багасгах, Ази Номхон далайн бүс нутгийн аж ахуйн нэгжүүд цахилгаан машин, аккумулятор, нарны зай, эм, эмийн хэрэгсэл ухаалаг утас зэрэг нарийн

төвөгтэй, өндөр үнэ цэнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх таатай боломжийг нээж байна. Угсралтын ажлаас гадна аж ахуйн нэгжүүд эд анги үйлдвэрлэх, судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийх, улмаар үйлчилгээний салбарт нэвтэрч буй дижитал технологийн давуу талыг ашиглан үйлдвэрлэлээс бий болж буй үнэ цэнийг өсгөх үйлчилгээнд хамтран оролцож хөгжиж байна.

Эдгээр салбар нь залуу үеийнхний хүсэл тэмүүллийг биелүүлэхэд туслах ёстой.

Үйлдвэрлэлийн салбар нь бага, дунд орлоготой улс орнуудын эдийн засгийн өсөлт, ялангуяа, хөнгөн болоод дунд технологийн салбарт залуучууд хөдөлмөр эрхлэх чухал эх үүсвэр хэвээр байх болно. Гэхдээ үйлдвэрлэгчдэд нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хувилбарыг сонгох шаардлага тавигдах бөгөөд энэ нь зардал болоод тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж болзошгүй юм. Хөдөлмөр эрхлэх боломж нь хөдөлмөрийн эрэлт хэрэгцээний бүтэц, технологийн хөгжлийн хурд, ажиллах хүчний ур чадварын чанараас хамаарна. Мөн зарим ажилчид өөрсдийн чадавх боломжоо бүрэн ашиглахын тулд гадаад орнууд руу цагаачлах нь гарцаагүй.

Боловсрол, ур чадварыг сайжруулахад чиглэсэн хүн төвтэй арга хэмжээнүүдийн зэрэгцээ эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд түлхэц өгөх хэд хэдэн бодлогын тэргүүлэх чиглэл бий болж байна. Үр дүнтэй манлайлал, засаглалын тогтолцоо нь үндэс суурь болно. Макро эдийн засгийн тогтвортой байдал нь төсвийн сахилга батыг шаардахын зэрэгцээ шинэчлэлийг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн бүс нутгийн эрчимтэй өсөн нэмэгдэж буй дундаж давхаргын бий болгосон зах зээлд нэвтрэхийн тулд улс орнууд болон үйлдвэрлэл эрхлэгчид нь гадаад нөхцөл байдалд анхаарлаа илүүтэй хандуулах хэрэгтэй - бүс нутгийн худалдааны харилцааг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ дэлхийн түвшинд харилцаа холбоог бэхжүүлэхийг эрэлхийлэх нь чухал. Бизнесийн үйл явцыг оновчтой болгох, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг шинэчлэх, гарааны бизнес, бизнес эрхлэлтийг дэмжих нь зах зээлийн

өрсөлдөх чадварт нэн чухал хэвээр байна. Техно-үйлдвэрлэлийн стратегид инновацыг дэмжих, зах зээлийн анхааруулгыг эрэмбэлэх, компаниудад зах зээлд нэвтрэх боломжийг олгох, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

Өөрчлөлтийн эрчийг нэмэгдүүлж, шинэ санааг амьдралд хэрэгжүүлэхийн тулд шинэчлэлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо үр дүнтэй эсэхэд илүү их анхаарал хандуулах шаардлагатай.

Өмнө өгүүлсэн зөвлөмжүүд нь тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэхээр арга хэмжээ авсан чухам тэр л цагт бодитой болно. Эрч хүчтэйгээр 'Ирээдүйгээ бүтээх'-ийн тулд ардчиллын ухралт, популизм, туйлшрал ихсэж, төрийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл буурч байгаа энэ үед улам төвөгтэй болж буй шинэчлэлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үр дүнтэй механизмыг тодорхойлоход илүү их анхаарал хандуулах шаардлагатай. Бодлого боловсруулагчид ч мөн нийгмийн сүлжээг идэвхтэй ашиглаж, мэдээллийн бохирдолтой тэмцэх хэрэгтэй.

Стратеги төлөвлөлтөөс үйл хэрэгт шилжихийн тулд манлайлагчдын болоод олон нийтийн сэтгэлгээг өөрчлөх, хэрэгжилтийг хангах илүү хүчирхэг байгууллагууд шаардлагатай. Жинхэнэ өөрчлөлт нь сайтар бодож тунгаан бодит байдалд анхаарал хандуулах, түүнчлэн стратегийн алхам хийх чадварт тулгуурлана. Цар тахлын үед харуулсанчлан, тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагыг самбаачлан тооцож, зайлшгүй хийх шаардлагатай өөрчлөлтүүдийг шуурхай зохицуулах чадавхтай засаглал нэн чухал.

Ирээдүйгээ бүтээх засаглал нь хүсэл эрмэлзлэл боловч үл гүйцэлдэх зүйл огт биш юм. Энэ нь тасралтгүй суралцах, туршиж судлах, сайжруулах үйл явц, аян юм. Бүс нутаг нь өргөн хүрээний засаглалын бүтэцтэй хэдий ч ирээдүйн боломжуудыг ашиглахын тулд зайлшгүй шаардлагатай шинэчлэлийг хийх механизмаас бүгд ашиг тус хүртэх болно.

Ирээдүйгээ бүтээх засаглалын тогтолцоо нь гурван үндсэн шинжийг агуулна. Үүнд:

- **Урьдчилан тооцоолох чадвар** – Төрөл бүрийн анхааруулгыг хүлээн авч, янз бүрийн хувилбаруудыг тооцоолох замаар байгаль орчинд учирч болзошгүй сорилт, боломж, өөрчлөлтийг урьдчилан таамаглах чадвартай байх.
- **Дасан зохицох чадвар** – Шинэ мэдээлэл, өөрчлөгдөж буй нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлийн өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байх – зөвхөн суралцахад төдийгүй давтах ёсгүй сургамжаас ангижрахад чиглэсэн олон удаагийн арга хэмжээ авах.
- **Шуурхай байх чадвар** – Төсвийн шийдвэр гаргахдаа талуудын нягт хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурлаж хөрөнгө нөөцийг дахин хуваарилах зэргээр шинэ мэдээлэл, гэнэтийн үйл явдалд хурдан шаламгай хариу үйлдэл үзүүлэх чадвартай байх.

Хурдацтай хөгжиж буй энэ үед дараах арга замаар өөрчлөлтийн эрчийг нэмэгдүүлэх нь чухал. Тухайлбал,

- **Улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх** – Улс төрийн удирдагчид, бодлого шийдвэр гаргагчид шинэ хандлагыг баримтлах эсэхдээ эргэлзэж, шинэ санаа гаргах мэдлэг, чадвар дутмаг байгаа мэт санагдаж магадгүй юм. Энэ тохиолдолд тэд тогтвортой бөгөөд судалгаатай зөвлөгөө өгч чадах сайн бэлтгэгдсэн, чадварлаг зөвлөхүүдээс 'стратегийн дэмжлэг'

ийг авах боломжтой.

- **Хамтын манлайлал үзүүлэх** – Энэ нь санал зөрөлдөөнийг арилгах, гол чухал бодлогыг тал талаас нь хэлэлцэн зөвшилцөхөд зайлшгүй шаардлагатай. Энэ нь зөрчилдөөнийг шийдвэрлэх, өрсөлдөгч бүлгүүдийн хоорондын яриа хэлцлийг хөнгөвчлөх дотоод зуучлалд суурилсан байж болно.
- **Иргэдийн оролцоог дэмжих** – Иргэдийн идэвхтэй оролцоо, олон талт түншлэл нь олон талын үзэл бодлыг уралдуулан хэлэлцэж, нийгмийн эв нэгдлийг дэмжиж, асуудлыг анхан шатны түвшинд нь шийдвэрлэх боломж олгоно. Уламжлалт оролцооны хэлбэрээс гадна иргэд цахим засаглал, инновацийн платформоор дамжин оролцох боломжтой.

Улс орон бүр өөрийн онцлогт тохирсон шийдлийг сонгож болох ч нэгдсэн аргачлал, чиглэлийг баримталснаар ашиг тусыг нь бүгд хүртэх болно. Эдийн засгийн огцом өсөлт дангаар хангалтгүй. Хүний хөгжлийг дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийг сааруулахгүй. Түүнчлэн хэрэгжүүлэх арга хэмжээ авахгүйгээр ямар ч стратеги амжилтанд хүрэхгүй. Харин үүний оронд, улс орнууд энэхүү илтгэлээр зөвлөж буй хүний хөгжлийг үндсэн зорилго болгох, эдийн засгийн стратегийг шинэчлэн тодорхойлох, бодитой өөрчлөлт гаргахыг зорих гэсэн шинэ хандлагын бүрэлдэхүүн гурван хэсгийг бүхэлд нь ашиглах боломж байна.



United Nations Development Programme

One United Nations Plaza

New York, NY 10017

www.undp.org

© UNDP 2023